## “ГТХЗНТ” УТҮГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН 2022 ОНЫ 5 ДУГААР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022.06.08

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

“ГТХЗНТ” УТҮГ-ын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тулгуурлан батлуулсан нэгжүүдийн 5 дугаар сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулах, удирдлага, ажилтнуудыг мэдээллээр хангаж, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжруулах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал**

Нэгжүүдийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг төлөвлөгөөнд урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулж хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалаар үнэлэв.

**Үнэлэлт**

Нэгжүүдийн 4 дүгээр сарын төлөвлөгөөнд тусгагдсан нийт 56 ажлын хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтээр үзүүлэв.

| Нэгжийн нэр | Төлөвлөсөн ажлын тоо | Үүнээс | | | | | | | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100% | 90% | 70% | 50% | 30% | 0% | Хугацаа болоогүй | |
| Захиргаа, санхүүгийн хэлтэс | 17 | 14 | - | - | - | 3 | - | - | 87.6 |
| Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт, судалгааны хэлтэс | 10 | 9 | - | 1 | - | - | - | - | 97.0 |
| Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтэс | 15 | 14 | - | - | - | - | 1 | - | 93.3 |
| **Дүн** | **42** | **37** | **-** | **1** | **-** | **3** | **1** | **-** | **91.9** |

**Дүгнэлт:**

1/ Тайлант сард Захиргаа, санхүүгийн хэлтэс 17 ажлыг төлөвлөж хэрэгжүүлснээс 87,6%-ийн биелэлттэй, өмнөх сартай харьцуулахад төлөвлөгөөний биелэлт 1.64%-иар өссөн дүнтэй байна.

2/ Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт, судалгааны хэлтэс 10 ажлыг хэрэгжүүлснээс 97,0%-ийн биелэлттэй, өмнөх сартай харьцуулахад 7,0%-иар өссөн дүнтэй байна.

3/ Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтэс 15 ажлыг хэрэгжүүлснээс 93,3%-ийн биелэлттэй, өмнөх сартай харьцуулахад 2.2%-иар өссөн дүнтэй байна.

4/ Төвийн дүнгээр 42 ажлыг хэрэгжүүлснээс 91,9%-ийн биелэлттэй, өмнөх сартай харьцуулахад 3,3%-иар өссөн үзүүлэлттэй байна.

**Санал зөвлөмж:**

1/ Төвийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд "хэрэгжих шатанд" 70%-тай 3, "эрчимжүүлэх шаардлагатай" 50%-тай 5, "үр дүнгүй" 30%-тай 3, "хэрэгжээгүй" 0%-тай 2, нийт 13 арга хэмжээ байгаад анхаарч, тухайн арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж зорилтот түвшинд бүрэн хүргэх төлөвлөлт, зохион байгуулалт, гүйцэтгэлийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хариуцлагыг чангатгах, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах, үр дүн, ахиц гараагүй тохиолдолд хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулах;

2/ Нэгж, ажилтнууд хөдөлмөрийн дотоод журмын 5.2.6, 5.2.7-д заасны дагуу нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, захирлын тушаалаар өгсөн үүрэг даалгавар, туслах чанараар баталсан бусад төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах;

3/ Төвийн 2022 оны үйл ажиллагаанд эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбогдуулан захирлын зөвлөлийн хурлаас гарсан шийдвэр, захирлын шуурхай зөвлөгөөний үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах;

4/ Төвийн захирлын 2022 оны А/24 дүгээр тушаалын хүрээнд зохион байгуулалтын бүтцийн нэгж доторх ажлын ачаалал жигд эсэхийг шинжилж, чиг үүргийн хуваарилалтыг оновчтой болгох, албан тушаалын тодорхойлолтод заагдаагүй боловч хийгддэг ажлууд, эсвэл албан тушаалын тодорхойлолтод заагдсан боловч хийгддэггүй ажлуудыг тодорхойлж, тухайн албан тушаалын чиг үүргийг бодитой тогтоох арга хэмжээг хэрэгжүүлэх;

5/ Төвийн захирлын 2022.06.10-ны өдрийн А/42 дугаар тушаалаар ажил мэргэжлийн жагсаалт батлагдсантай холбогдуулан Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулах, АБТ боловсруулахад ажлын байрны шинжилгээг үндэслэх;

6/ ЗТХЯ-ны ТНБД-ын 2022.02.16-ны өдрийн 03/668 дугаартай албан бичгийн дагуу хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн тайлан биелэлтийг ЗТХЯ-ны БТГ-т хагас жилээр тайлагнах;

7/ ЗТХЯ-ны улсын ахлах байцаагчийн 2022.02.18-ны өдрийн 09-01/009 дугаартай албан шаардлагын биелэлтийг ЗТХЯ-нд тайлагнах;

8/ ЗТХЯ-ны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үүрэг бүхий орон тооны бус дэд зөвлөлийн 2022 оны ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах;

9/ ЗТХ-ийн 2022 оны "Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх тухай" А/50 дугаар тушаалын 2 дахь заалтыг хэрэгжүүлж өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг ЗТХЯ-ны ТЗУГ-т тайлагнах;

10/ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

**ТАНИЛЦСАН:**

"ГТХЗНТ" УТҮГ-ЫН ЗАХИРАЛ А.БУЯННЭМЭХ

ТНУАСХ-ИЙН ДАРГА Д.ТӨГСЖАРГАЛ

ГХБАБМХ-ИЙН ДАРГА Ц.ОЮУНБАТ

**БОЛОВСРУУЛСАН:**

ХШҮДХА Э.ОСОРЖАМАА

## ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ 5 ДУГААР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022.06.03

| № | ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ | ХҮРЭХ ТҮВШИН | БИЕЛЭЛТ |
|---|---|---|---|
| 1 | Нэгжүүдийн 04 дүгээр сарын төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх **Э.Осоржамаа** | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг удирдлагад танилцуулж эйбл системд байршуулж мэдээлсэн байна | Нэгжүүдийн 4 дүгээр сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг удирлагад 2022.04.05-ны өдөр танилцуулж эйбл системд байршуулж мэдээлсэн. **Хэрэгжилт 100%** |
| 2 | Ажилтнуудын 3, 4 дүгээр сарын цагийн бүртгэлд дотоод хяналт хийх **Э.Осоржамаа** | Тайланг захиралд танилцуулсан байна | Ажилтнуудын 3 дугаар сарын цагийн бүртгэлд 2022.05.03-ны өдөр, 4 дүгээр сарын цагийн бүртгэлд 2022.05.16-ны өдөр дүн шинжилгээ хийж, тайланг 2022.05.17-ны өдөр захиралд танилцуулсан. **Хэрэгжилт 100%** |
| 3 | Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай хуралдааны үүрэг даалгаврын хэрэгжилтийг ЗТХЯ-нд тайлагнах **Э.Осоржамаа** | Биелэлтийг тогтоосон хугацаанд ЗТХЯ-ны ТЗУГ-т тайлагнасан байна | Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай хуралдааны үүрэг даалгаврын биелэлтийг ЗТХЯ-ны ТЗУГ-ын мэргэжилтэн А.Оюунболдод 2022.05.06, 2022.05.20, 2022.05.27-ны өдөр, Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаал, Зам, тээврийн хөгжлийн сайдын албан даалгаврын биелэлтийг 2022.05.05, 2022.05.17-ны өдөр ЗТХЯ-ны ХШҮДАГ-ын мэргэжилтэн Б.Угандулам, Л.Шинэчимэг нарт цахим шуудангаар тус тус тайлагнасан. **Хэрэгжилт 100%** |
| 4 | Ажилтнуудын боловсруулсан баримт бичгийг төслийн эрх зүйн үндэслэл, найруулга зүйг албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, журам, стандартын дагуу хянах **Э.Осоржамаа** | Хууль тогтоомжийг зөв хэрэглэсэн, үндэслэлтэй, товч тодорхой, ойлгомжтой, утгын хувьд логик дараалалтай, зөв бичих дүрэм, найруулга зүйн талаас алдаагүй, албан ёсны, тогтсон үг хэллэгтэй байх зэрэг баримт бичигт тавигдах нийтлэг шаардлагад нийцүүлсэн байна | Аижлтнуудын боловсруулсан баримт бичгийн төслийг тухай бүр хянан шилжүүлсэн. **Хэрэгжилт 100%** |
| 5 | Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой обьект, үйл ажиллагааны гэрчилгээ хүссэн хуулийн этгээдийн баримт бичгийн бүрдлийг нягтлан шалгах **Э.Осоржамаа** | Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэмд заасан нөхцөл, шаардлагын дагуу хянан дүгнэлт гаргасан байна | Гэрчилгээжүүлэлтийн ажлын хэсгийн 2022.04.28, 2022.05.13-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу Тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлтийн цахим системд 20 хуулийн этгээдийн дүгнэлтийг оруулж, хурлын тэмдэглэлтэй танилцсан. Тайлант сард төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой гэрчилгээ хүссэн 45 байгууллагын 4058 хуудас баримт бичигтэй танилцаж, гэрчилгээжүүлэлтийн ажлын хэсгийн 2022.05.27-ны өдрийн хуралд оролцсон. **Хэрэгжилт 100%** |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | Налайх цэцэрлэгт хүрээлэнд мод тарих, тарьсан модоо арчлах ажлыг зохион байгуулах<br>**М.Оюун-Ундрам** | Мод тарилтын ажлыг зохион байгуулсан байна | Налайх цэцэрлэгт хүрээлэнгийн ачааллаас шалтгаалан 2022 оны мод тарилтын ажлыг Баянгол цэцэрлэгт хүрээлэнд 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, төвийн 14 ажилтан Хайлаас мод 60 ширхэг тарьсан. **Хэрэгжилт 100%** |
| 7 | Ажлын байрны шинжилгээ хийж, тайланг удирдлагад танилцуулах<br>**М.Оюун-Ундрам** | Тайланг удирдлагад танилцуулсан байна | Ажлын байрны шинжилгээ хийх ажлын хүрээнд ажлын ачаалал, давхардал, хийдлийн талаар google doc програмаар анкетын аргаар ажилтнуудаас судалгаа авч боловсруулалт хийсэн. Албан тушаалын тодорхойлолтын дагуу ажилтан тус бүрээс асуулгаар албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан мэдлэг боловсролын шаардлага, ерөнхий чиг үүргийн хэрэгжилтийн талаар судалгаа авч байна. **Хэрэгжилт 30%** |
| 8 | Хүний нөөц, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлыг холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэн шийдвэрлүүлэх<br>**М.Оюун-Ундрам** | Хууль, дүрэм журамд нийцүүлэн шийдвэрлүүлсэн байна | Хүний нөөц хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлыг хууль дүрмийн дагуу хийж гүйцэтгэсэн. Тайлант сард боловсон хүчний холбогдолтой Б тушаалын төсөл-10, үйл ажиллагааны холбогдолтой А тушаалын төсөл-4 төлөвлөж батлуулсан. Ээлжийн амралтын хуваарийн дагуу 1 ажилтны ээлжийн амралтыг олгож, ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтны тойрох хуудас, ажил хүлээлцэх акт үйлдэж, хувийн хэргийг хувилж өгсөн. **Хэрэгжилт 100%** |
| 9 | УБТЗ-ын нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажилтны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг зохион байгуулах<br>**М.Оюун-Ундрам** | Ажилтны эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулсан байна | 2022 оны ажилтны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх ээлжит үзлэгийг зохион байгуулж, Улаанбаатар төмөр замын нэгдсэн эмнэлэгт 2022 оны 05 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд нийт ажилтнуудыг хамруулсан. Нийт 26 ажилтан үзлэгт хамрагдахаас 22 ажилтан бүрэн хамрагдаж, 2 ажилтан үзлэг шинжилгээг үргэлжлүүлэн, 2 ажилтан хамрагдаагүй байна. **Хэрэгжилт 100%** |
| 10 | Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах<br>**С.Золзаяа** | | Төсвийн гүйцэтгэлийн мэдээг харьяа төрийн санд хүргүүлэн баталгаажуулсан. 2023 оны төсвийн төсөл болон 2024-2025 оны төсвийн төсөөлөлд тусгах саналыг бэлтгэн ЗТХЯ-ны БТГ-н мэргэжилтэн н.Цэрэнгомбод хүргүүлсэн. НДШ-ийн тайлан болон санхүүгийн дотоод үйл ажиллагаатай холбоотой тайлан мэдээг бэлтгэн хугацаанд нь хүргүүлж баталгаажуулсан. **Хэрэгжилт 100%** |
| 11 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах<br>**С.Золзаяа** | | Тухай бүрт бэлтгэн байршуулах 8 мэдээ, сар бүр байршуулах 1 мэдээг хугацаанд нь бэлтгэн шилэн дансны цахим хуудсанд байршуулан мэдээлсэн. **Хэрэгжилт 100%** |
| 12 | Орон сууцны барилгын БУА-ыг үргэлжлүүлэхэд шаардлагатай баримт бичиг, зөвшөөрлүүдийг гүйцэтгэгчтэй хамтран албажуулах, хяналт тавьж ажиллах<br>**Д.Дарьсүрэн** | | Хот байгуулалт, хөгжлийн газар батлагдсан барилгын архитектур төлөвлөлтийн даалгаврын дагуу шаардлагатай техникийн нөхцөлүүдийг авч, бусад баримт бичгийг бүрдлийг ханган ажиллаж байна. **Хэрэгжилт 30%** |

| | | | |
|---|---|---|---|
| 13 | БГД-ийн 20-р хорооны нутаг дэвсгэрт баригдах төвийн барилгын инженерийн дэд бүтцийн зураг төсөл, барилгын ажлын үнийн санал мэргэжлийн байгууллагаас авах **Д.Дарьсүрэн** | | БНСУ-ын Койка хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөлтэй уулзаж цаашид хамтран ажиллах барилгын зураг төсөл боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын талаар ярилцсан. **Хэрэгжилт 30%** |
| 14 | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, "Монгол бичиг"-ийн сургалтыг тус тус зохион байгуулах **Д.Дарьсүрэн** | | БГДНТБТ-тэй байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу 2022.05.16-ны өдөр "Авлигын эсрэг хууль", 2022.05.13-ны өдөр "Үндэсний бичиг", 2022.05.26-ны өдөр "Хүүхэд хамгаалал", "Хүүхдийн хөгжлийн онцлог" сэдвээр сургалт зохион байгуулж, нийт албан хаагчид хамрагдсан. **Хэрэгжилт 100%** |
| 15 | Байгууллагад ирсэн баримт бичгийг хүлээн авах, ангилах, бүртгэх, холбогдох ажилтанд шилжүүлэх **Б.Оюунчимэг, Г.Байгалмаа** | Төлөвлөгөөт ажил хийгдсэн байна | Байгууллагад ирсэн баримт бичгийг хүлээн авах, ангилах, бүртгэх, холбогдох ажилтанд шилжүүлж ажилласан. **Хэрэгжилт 100%** |
| 16 | Явуулах бичиг баримтыг хүлээн авч бүрдлийг шалгах, бүртгэх, илгээх, баримт бичгээр тавьсан асуудлын шийдвэрлэлтийн явцад хяналт тавих **Б.Оюунчимэг, Г.Байгалмаа** | Төлөвлөгөөт ажил хийгдсэн байна | Явуулах бичиг баримтыг хүлээн авч бүрдлийг шалгах, бүртгэх, илгээх, баримт бичгээр тавьсан асуудлын шийдвэрлэлтийн явцад хяналт тавьсан. **Хэрэгжилт 100%** |
| 17 | Байгууллагын үйл ажиллагаанд үүсч хөтлөгдсөн баримт бичиг, мэдээллийг ангилах, төрөлжүүлэх, мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулах **Б.Оюунчимэг, Г.Байгалмаа** | Төлөвлөгөөт ажил хийгдсэн байна | Байгууллагын үйл ажиллагаанд үүсч хөтлөгдсөн баримт бичиг, мэдээллийг ангилах, төрөлжүүлэх, мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулсан. Захирлын өдөр тутмын үйл ажиллагааг шуурхай зохицуулж, захирлын үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцлийг бүрдүүлэх, төвийн өдөр тутмын үйл ажиллагааны шуурхай мэдээ, мэдээллийг захирал болон холбогдох ажилтнуудад хүргэх, захирлаар шийдвэрлүүлэх асуудлыг шуурхай зохион байгуулж ажилласан. **Хэрэгжилт 100%** |

14*100=1400
3*30=90
17=1490/17=%=87.6%

## ТЭЭВРИЙН НЭГДСЭН УДИРДЛАГА, АВТОМАТЖУУЛАЛТ, СУУДАЛГААНЫ ХЭЛТСИЙН 05 ДУГААР САРД ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН НЭГТГЭСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ (Биелэлт)

| Зорилт | Хэмжих үзүүлэлт | Хянасан огноо | Гүйцэтгэлийн үнэлгээ | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| | | | Өөрийн | Удирдлагын | |
| **1. Галт тэрэгний хөдөлгөөний 2021-2022 оны өвлийн нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд ашиглалтын ажлын болон тоон үзүүлэлтээр дүн шинжилгээ хийх** | Дүн шинжилгээ хийж суурь бүтцүүдэд хүргүүлсэн байна. (100%) (100%) (100 %) | 2022-06-02 08:14 | 10.0% | 10.0% | **Б.Буманцэцэг** 22/05/23 Галт тэрэгний хөдөлгөөний 2021-2022 оны өвлийн нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд ашиглалтын ажлын болон тоон үзүүлэлтээр дүн шинжилгээ хийж 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 213 тоот албан бичгээр суурь бүтцүүдэд хүргүүлсэн. |
| **2. Г.Т. 6.1.1. Монгол Улсын төмөр замын сүлжээнд галт тэрэгний дугаарлалт хийх зааврын төслийг сайжруулан боловсруулж суурь бүтцүүдээс дахин санал авахаар хүргүүлэх** | Зааврын төслийг хүргүүлсэн байна (100%) (100%) (100% ) | 2022-06-02 08:14 | 10.0% | 10.0% | **Б.Буманцэцэг** 22/05/23 Монгол улсын төмөр замын сүлжээнд галт тэрэгний дугаарлалт хийх зааврын төслийг сайжруулан боловсруулж санал авахаар 2022 оны 05 дугаар сарын 23-ны 214 тоот албан бичгээр суурь бүтцүүдэд хүргүүлсэн. |
| **3. Г.Т. 6.1.2. "Өртөөний технологийн горим боловсруулах заавар"-ын төслийг холбогдох байгууллагуудаас санал авахаар хүргүүлэх** | Зааврын төслийг хүргүүлсэн байна (100%) (100%) (100% ) | 2022-06-02 08:15 | 10.0% | 10.0% | **Б.Буманцэцэг** 22/05/23 "Өртөөний технологийн горим боловсруулах заавар"-ын төслийг боловсруулж санал авахаар 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 207 тоот албан бичгээр суурь бүтцүүдэд хүргүүлсэн. |
| **4. Нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд хилийн галт тэрэг солилцоо, суурь бүтэц хоорондын галт тэрэг, вагон солилцоо, хөдөлгөөний зурмагийн тасалдал, нүүрс, төмрийн хүдэр, зэсийн ачилт үзүүлэлтээр дүн шинжилгээ хийх** | Нийт 2 удаа дүн шинжилгээ хийж viber группэд байршуулсан байна. (100%) (100%) (100 %) | 2022-06-02 08:15 | 10.0% | 10.0% | **Б.Буманцэцэг** 22/05/16 Нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд хилийн болон суурь бүтэц хоорондын галт тэрэг солилцоо, хөдөлгөөний зурмагийн тасалдал, нүүрс, төмрийн хүдэр, зэсийн ачилт үзүүлэлтээр дүн шинжилгээ хийж 5 дугаар сарын 2, 16-ны өдрүүдэд viber-т байршуулан удирдлагуудыг мэдээллээр хангасан. |
| **5. 2022 оны 04-р сарын зурмагийн тасалдалд дүн шинжилгээ хийж ЗТХЯ-г мэдээллээр хангах** | Зурмагийн тасалдалд дүн шинжилгээ хийж ЗТХЯ-д хүргүүлсэн | 2022-05-23 08:11 | 10.0% | 10.0% | **Б.Буманцэцэг** 22/05/12 2022 оны 4 дүгээр сарын зурмагийн тасалдалд дүн шинжилгээ хийж 2022 оны 5 дугаар сарын 12ны |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | байна. (100%) (100%) (100 %) | | | | өдрийн 196 тоот албан бичгээр ЗТХЯ-руу хүргүүлж мэдээллээр хангасан. |
| **6. Экспортын ачаа хүргэх хугацаа хэтэрсэн вагоны тоон судалгаа 14 хоног тутам гаргаж танилцуулах** | Мэдээллийг гаргаж удирдлагуудад танилцуулсан байна (100%) (100%) (100% ) | 2022-06-02 08:15 | 10.0% | 10.0% | **Б.Буманцэцэг** 22/05/16<br>Экспортын ачаа хүргэх хугацаа хэтэрсэн вагоны тоон судалгаа гаргаж 5 дугаар сарын 2, 16-ны өдрүүдэд viber-т байршуулан удирдлагуудыг мэдээллээр хангасан. |
| **7. 11.1.1.Салбарын болон төвийн үйл ажиллагааг сурталчлах видео контент, мэдээ мэдээлэл бэлтгэх** | Салбарын болон төвийн үйл ажиллагааг сурталчлах видео контент, мэдээ мэдээлэл бэлтгэнэ. (100%) (100%) (10 0%) | 2022-06-02 08:17 | 10.0% | 10.0% | **Д.Өлзийсайхан** 22/05/30<br>5-р сарын 03-нд “Нэгдсэн зурмагийн дүн шинжилгээ (сүүлийн 15 хоногоор 04-р сар), 5-р сарын 05-нд “Эчнээ хөтөлбөрийн бүртгэлийн талаар”, 5-р сарын 06-нд “ГТХЗНТ-ийн мэргэжилтнүүдийн томилолт”, 5-р сарын 09-нд “Инженер-Ирээдүй төгөл”, “Тэр бум мод” хөдөлгөөнд нэгдлээ, 5-р сарын 16-нд “ИрГУПС-ын танилцуулга”, 5 сарын 16-нд “Хөдлөх бүрэлдэхүүний 5 дугаар сарын мэдээлэл” (эхний 15 хоногоор), “Нэгдсэн зурмагийн дүн шинжилгээ” (эхний 15 хоногоор 05-р сар), 5-р сарын 04,11, 17, 23, 24 “БНСУ-ын "Korea Railroad Research Institute" -ийн судалгааны гол технологиуд цуврал сэдвээр зурган болон видео контент бэлтгэн, Ган зам сонинд 2 удаа мэдээ нийтлүүлэн төвийн үйл ажиллагааг сурталчлан ажилласан. |
| **8. 2022 оны магистрын эчнээ хөтөлбөрт элсэгчдийн бүртгэлийн ажлыг зохион байгуулж, 1-р курсийн оюутнуудын хэлний бэлтгэл хичээлийг дуусгах.** | Магистрын эчнээ хөтөлбөрт элсэгчдийн бүртгэлийн ажлыг зохион байгуулна. (100%) (100%) ( 100%) | 2022-06-02 08:17 | 10.0% | 10.0% | **Д.Өлзийсайхан** 22/05/30<br>2022 оны магистрын эчнээ хөтөлбөрт 14 элсэгчийн материал хүлээн аваад байна. Материалуудыг PDF болгон цэгцлээд ИрГУПС-д файлаар явуулна. 1-р курсын оюутнуудын хэлний бэлтгэл хичээл амжилттай дууссан. |
| **9. 1.1.1 БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/-тай хамтран хэрэгжүүлэх “Галт** | БНСУ-ын төслийн координатуудтай цахим орчинд уулзалт зохион байгуулсан | 2022-06-02 08:18 | 10.0% | 10.0% | **О.Оюунболд** 22/05/31<br>- Төслийн зөвлөх /PMC/ багтай 2022, 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэх цахим уулзалтыг 06 сарын 07-нд зохион байгуулахаар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн барилга барих, үйл ажиллагаагчадавхжуулах замаар Монгол Улсын төмөр замын өрсөлдөх чадварыг сайжруулах төсөл”-ийн БНСУ-ын төслийн координатуудтай 2022 болон 2023 онд төсөлтэй холбоотой хийх ажлын талаар цахимаар уулзалт зохион байгуулах.** | байна. (100%) (100%) (100 %) | | | | болсон бөгөөд /PMC/ багаас энэхүү төлөвлөгөө боловсруулан ГТХЗНТ-д өгөхөөр зөвшилцсөн.<br><br>- 5 сарын 24-нд КОЙКА-гийн суурин төлөөлөгчийн газарт төслийн барилгын ажлын үе шатанд хийгдэх ажлын төлөвлөгөөг хэлэлцсэн.<br><br>- КОЙКА-гаас Ашигт малтмал, газрын тосны газарт хэрэгжүүлж буй төсөл хариуцаж буй төслийн мэргэжилтэнтэй уулзаж туршлага судалсан. |
| **10. 7.1.5. 3-р багтай хамтран "Төмөр замын тээврийн салбарын галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны виртуал /симулятор/ орчны сургалтын танхим байгуулах" төслийг хураангуйлан боловсруулж СЯ-нд хүргүүлэх** | Төслийн хураангуйлан боловсруулж СЯ-нд хүргүүлсэн байна. (100%) (100%) (100 %) | 2022-06-02 08:18 | 10.0% | 10.0% | **Д.Өлзийсайхан** 22/05/30<br>3-р багтай хамтран "Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны /симулятор/ сургалтын төв байгуулах" төслийн саналыг 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 197 тоот албан бичгээр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбатад 32 хуудас материал / англи,монгол хэл дээр/ хүргүүлсэн. |
| **Нийт** | | | 100.0% | 100.0% | |

**Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, бүртгэл, мэдээллийн хэлтсийн 2022 оны 5 дугаар сарын ажлын төлөвлөгөө (Биелэлт)**

| Зорилт | Үйл ажиллагаа | Хэмжих үзүүлэлт | Гүйцэтгэлийн үнэлгээ | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| | | | Өөрийн | Удирдлагын | |
| **1. Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, хадгалах, ашиглах** | Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, хадгалах, ашиглах | • Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж ажилласан байна. (100%) (100%) (100%) | 6.3% | 6.3% | **Б.Гэрэлтуяа** 22/05/31 Төмөр замын тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн санд хоногийн 775, 7 хоногийн 40, сар 50, улирлын 20 мэдээ байршиж байна. |
| **2. Статистик мэдээллийг нэгтгэн боловсруулж төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон үндэсний статистикийн хороог салбарын мэдээ мэдээллээр хангах** | Статистик мэдээллийг нэгтгэн боловсруулж төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон үндэсний статистикийн хороог салбарын мэдээ мэдээллээр хангах | • Мэдээ мэдээллээр хангаж ажилласан байна. (100%) (100%) (100%) | 6.3% | 6.3% | **Б.Гэрэлтуяа** 22/05/31 Статистик мэдээллийг нэгтгэн боловсруулж ТЗДТБХЗГ болон БТГ-т 2022.05.20-ны өдрийн 205 тоот албан бичгээр мэдээ мэдээлэл хүргүүлж ажилласан. |
| **3. Салбарын статистик мэдээллийг ашиглан инфо график гарган мэдээллийн самбар болон төвийн цахим хуудсанд байршуулан мэдээлэх** | Салбарын статистик мэдээллийг ашиглан инфо график гарган мэдээллийн самбар болон төвийн цахим хуудсанд байршуулан мэдээлэх | • Мэдээлж ажилласан байна. (100%) (100%) (100%) | 6.3% | 6.3% | **Б.Гэрэлтуяа** 22/05/31 Салбарын статистик мэдээллийг ашиглан инфо график гарган мэдээллийн самбар болон төвийн цахим хуудсанд байршуулан ажилласан. |
| **4. Төмөр замын суурь бүтэц эзэмшигчдийн ачаа, тээврийн үзүүлэлтүүдийг** | Төмөр замын суурь бүтэц эзэмшигчдийн ачаа, тээврийн үзүүлэлтүүдийг харуулсан мэдээлэл бэлтгэн төвийн viber хуудсанд байршуулах | • Мэдээлэл байршуулан ажилласан байна. (100%) (100%) (100%) | 6.3% | 6.3% | **Б.Гэрэлтуяа** 22/05/31 Төмөр замын суурь бүтэц эзэмшигчдийн ачаа, тээврийн үзүүлэлтийг харуулсан мэдээ мэдээлэл бэлтгэн төвийн viber |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **харуулсан мэдээлэл бэлтгэн төвийн viber хуудсанд байршуулах** | | | | | хуудсанд байршуулан ажилласан. |
| **5. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд шинээр код болон дугаар олгох, дугаарыг баталгаажуулах, чингэлгийн бүртгэл хийх, төвийн мэдээллийн нэгдсэнд санд бүртгэх** | Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд шинээр код болон дугаар олгох, дугаарыг баталгаажуулах, чингэлгийн бүртгэл хийх, төвийн мэдээллийн нэгдсэнд санд бүртгэх | • Төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хийж гүйцэтгэнэ. (100%) (100%) (100%) | 6.3% | 6.3% | **3.Мөнхтуяа** 22/05/31 "Түмтийн зам групп" ХХК-ийн хилээр оруулж ирэх хөдлөх бүрэлдэхүүний баримт бичгийн бүрдэл дутуу байгааг 2022.05.03-ны 175 тоотоор буцаасан. 176 тоотоор "Эвт-Аян" ХХК-ийн түрээсийн 200 чингэлгийг, 05.05-ны 179 тоотоо "Монцемент билдинг материалс" ХХК-ийн 9 хагас вагоны дугаарыг баталгаажуулж, 05.06-ны 187 тоотоор "Шийдаложистик" ХХК-ийн 50 тавцант вагонд шинээр дугаар олгож, 05.09-ний 190 тоотоор "Патрикейн" ХХК-ийн түрээсийн 55 тавцант вагоныг, 05.10-ны 192 тоотоор "Патрикейн" ХХК-д эзэмшигч түрээслэгчийн Т17 кодыг олгож, 05.19-ний 201 тоотоор "Дулаан винг" ХХК-ийн түрээсийн чингэлэг тээврийн 19 тавцант вагоныг, 202 тоотоор "Монголиан транс ложистик" ХХК-ийн чингэлэг тээврийн зориулалтаар өөрчлөн тоноглосон 10 вагонд шинээр дугаар олгон, 221 тоотоор "Тонж ложистик" ХХК-ийн түрээсийн 2 цистерн вагоныг хөдлөх бүрэлдэхүүний |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээллийн нэгдсэн санд бүргэсэн. “УБТЗ” ХНН-ийн 5.05-ний тоотоор 180 тоотоор 100 тавцант вагоны, 05.09-ний 191 тоотоор 4 тавцант вагоны, 5.12-ны 198 тоотоор 10 хагас вагоны, 05.31-ны 220 тоотоор 400 тавцант вагоны дугаарын давхцлыг шалгуулахаар “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн СБМТА-д хүргүүлэн, хариуг хүлээн авсан. 2022 оны 5 дугаар сарын Хөдлөх бүрэлдэхүүний статистик мэдээг сард 2 удаа /сарын эхний болон сүүлийн 15 хоногоор/ бэлтгэн боловсруулж төвийн удирдлага, мэргэжилтнүүдэд танилцуулсан. |
| **6. Төвийн компьютер, програм хангамж болон албан хэрэг хөтлөлтийн систем, сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах** | Төвийн компьютер, програм хангамж болон албан хэрэг хөтлөлтийн систем, сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах | • Хэвийн ажиллагааг хангасан байна (100%) (100%) (100%) | 6.3% | 6.3% | **Г.Баттөр** 22/06/02<br>Энэ сард төвийн ажилтнуудын компьютер мэдээллийн технологийн төхөөрөмжүүдэд алдаа доголдол гараагүй хэвийн ажилласан |
| **7. Зам тээврийн салбарын өгөгдөл солилцооны нэгдсэн платформ дээр төмөр замын тээврийн статистик мэдээний өгөгдлийн загварыг үүсгэх** | Зам тээврийн салбарын өгөгдөл солилцооны нэгдсэн платформ дээр төмөр замын тээврийн статистик мэдээний өгөгдлийн загварыг үүсгэх | • Хөгжүүлэлтийн ажлыг хийсэн байна (100%) (100%) (100%) | 6.3% | 6.3% | **Г.Баттөр** 22/06/02<br>Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлтийн маягт №6 ыг архитектурын элементээр үүсгэн, Ачаа тээвэрлэлт, ачаа эргэлт, зорчигч тээвэрлэлт, зорчигч эргэлт болон бусад үзүүлэлтээр чарт, холбогдох |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | цэсийг үүсгэн удирдлагын дашбоардыг хөгжүүлэх ажлыг гүйцэтгэсэн. |
| **8. Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэлийн мэдээллийн сангийн модель загварыг ЗТСӨСН платформ дээр үүсгэх, нэр томьёог тодорхойлж оруулах** | Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэлийн мэдээллийн сангийн модель загварыг ЗТСӨСН платформ дээр үүсгэх, нэр томьёог тодорхойлж оруулах | • Бүртгэлийн програмын туршилтын бүрэн хувилбарыг үүсгэсэн байна (100%) (100%) (100%) | 6.3% | 6.3% | **Г.Баттөр** 22/06/02 Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлийн програмд Монгол Улсад хилээр орж ирэн дугаар авсан өмчлөлийн ачааны вагонуудыг байршуулах ажлыг гүйцэтгэн, дугаарын хяналтын оронг тооцоолох хэсгийн хөгжүүлэлтийг үргэлжлүүлэн хийж байна |
| **9. Төвийн цахим хуудас, олон нийтийн сүлжээний /фэйсбүүк/ хуудаст мэдээ мэдээлэл, контент байршуулах журамын төслийг батлуулах** | Төвийн цахим хуудас, олон нийтийн сүлжээний /фэйсбүүк/ хуудаст мэдээ мэдээлэл, контент байршуулах журамын төслийг батлуулах | • Төслийг батлуулсан байна (100%) (70%) (100%) | 4.4% | 4.4% | **Г.Баттөр** 22/06/06 Журмын төсөлд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд нэмэлт сайжруулалтыг тусгаж батлуулах болсон тул төслийг буцаан хяналтад шилжүүлсэн байна. |
| **10. Тээврийн хэрэгслийн баталгаажуулалтын орчуулга хянуулах** | Тээврийн хэрэгслийн баталгаажуулалтын орчуулга хянуулах | • Орчуулгын төслийг хянуулсан байна (100%) (100%) (100%) | 6.3% | 6.3% | **Д.Бат-Оргил** 22/06/06 Тээврийн хэрэгслийн /вагон, зүтгүүр/ баталгаажуулалтын схемын орчуулгыг АТҮТ-ийн баталгаажулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Мөнхзулаар гүйцэтгүүлсэн. Зохих залруулгыг гүйцэтгэсэн. ажлын биелэлт 100%. |
| **11. Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд** | Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, нөхөн олгох баримт бичгийн бүрдлийг нягтлан | • Хүсэлтийн баримт бичгийн бүрдлийг нягтлан шалгаж, санал дүгнэлт гарган ажлын хэсгээр хэлэлцүүлсэн байна. (100%) (100%) (100%) | 6.3% | 6.3% | **Б.Жавзандулам** 22/05/31 Тайлант хугацаанд 9 хүсэлтийн баримт бичгийг нягтлан шалгаж, санал дүгнэлт гарган ажлын хэсэгт шилжүүлэн, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, нөхөн олгох баримт бичгийн бүрдлийг нягтлан шалгах, санал дүгнэлт гаргах, шийдвэрлүүлэхээр уламжлах** | шалгах, санал дүгнэлт гаргах, шийдвэрлүүлэхээр уламжлах | | | | танилцуулсан. Ажлын хэсгийн ээлжит хурлыг зохион байгуулж 31 аж, ахуй нэгж байгууллагын хүсэлтийг хэлэлцүүлсэн. Холбогдох ажлыг хийж гүйцэтгэн гэрчилгээжүүлэлтийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн. |
| **12. Удирдлагаас цаг үеийн болон бусад асуудлаар өгсөн үүрэг даалгавар, дотоод ажлыг хийж гүйцэтгэх** | Удирдлагаас цаг үеийн болон бусад асуудлаар өгсөн үүрэг даалгавар, дотоод ажлыг хийж гүйцэтгэх | • Дэд даалгаварыг хийж гүйцэтгэсэн байна (100%) (100%) (100%) | 6.3% | 6.3% | **Б.Гэрэлтуяа** 22/06/02 ЗТХЯ-ны ХШҮДАГ-ын төмөр замын тээврийн байцаагч нарын зарласан "Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг зохицуулалтын журам" , "Төмөр замын байгууллагууд харилцан мэдэээлэл солилцох журам" -д нэмэлт өөрчлөлт оруулах, сайжруулахтай холбоотой хуралд оролцон цаашид журамд анхаарах, сайжруулах зүйл заалтын талаар санал солилцсон. |
| **13. Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүдийн хүсэлтийг хянах, мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, мэдээллээр хангах** | Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүдийн хүсэлтийг хянах, мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, мэдээллээр хангах | • Мэдээллийн санг бүрдүүлж, хөтөлж мэдээллээр хангаж ажилласан байна. (100%) (100%) (100%) | 5.5% | 5.5% | **Б.Жавзандулам** 22/05/31 Аж ахуй нэгж, байгууллагын бүртгэлийг хөтөлж, мэдээллийн санг тогтмол бүрдүүлэн ажиллаж байна.Тайлант хугацаанд 33 хүсэлтийг үзэж, танилцан мэдээлийн санд нэмж, бүрдүүлсэн. |
| **14. Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай** | Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ | • Хуулийн этгээдийн хүсэлтийг нягталж, ажлын хэсгийн | 6.3% | 6.3% | **Н.Номин** 22/05/31 Гэрчилгээжүүлэлттэй холбоотойгоор тайлант |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, нөхөн олгох баримт бичгийн бүрдлийг нягтлан шалгах, санал дүгнэлт гаргах, шийдвэрлүүлэхээр уламжлах, гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сан үүсгэх, хөтлөх ажлыг хэрэгжүүлэх** | олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, нөхөн олгох баримт бичгийн бүрдлийг нягтлан шалгах, санал дүгнэлт гаргах, шийдвэрлүүлэхээр уламжлах, гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сан үүсгэх, хөтлөх ажлыг хэрэгжүүлэх | дүгнэлтийг ЗТХЯ-нд уламжилсан байна. (50%) (100%) (100%)<br>• Мэдээллийн нэгдсэн сан үүсгэн хөтлөсөн байна. (50%) (100%) (100%) | | | хугацаанд төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим обьект, үйл ажиллагаат гэрчилгээжүүлэх хүсэлтийг 93 аж ахуй нэгж, байгууллага ирүүлсэн.<br>Хүсэлт ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийн хүсэлт дараах байдлаар шийдвэрлэгдсэн байна. Үүнд:<br>· Баримт бичгийн бүрдэл дутуу шалтгаанаар буцаагдсан – 16<br>· Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж буцаасан – 11<br>· Ажлын хэсгийн хурлаар дэмжигдсэн – 38<br>· Ажлын хэсгийн хурлаар ороход бэлэн болсон – 11<br>· Хүсэлт ирүүлсэн, одоогоор хянагдаагүй байгаа – 13<br>· Гэрчилгээ олгогдсон – 7<br><br>- Ажлын хэсгийн 2 удаа (5-р сарын 13, 27-ны өдөр)-ийн хурал хуралдсан. 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | №09 тоот хурлаар нийт 30 аж ахуйн нэгжийн 39 гэрчилгээ шинээр олгох болон сунгуулах асуудлыг хэлэлцсэн. Үүнээс:<br>· Шинээр олгохоор шийдвэрлэгдсэн: 5<br>· Сунгахаар шийдвэрлэгдсэн: 10<br>· Дараагийн хурлаар шийдвэрлэхээр хойшлуулсан: 11<br>· Буцаахаар шийдвэрлэгдсэн: 4<br>Хурлын тэмдэглэлийг хөтөлж ажлын хэсгийн гишүүдэд танилцуулан, гэрчилгээг олгох 15 аж ахуйн нэгж (22ш гэрчилгээ)-ийг Зам, тээврийн хөгжлийн яаманд шилжүүлсэн. Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн А141, А142, А143, А144, А145 дугаар тушаалын дагуу 15 аж ахуйн нэгжийн 22 ширхэг гэрчилгээг хэвлэн Төвийн захирлаар баталгаажуулан авч аж ахуйн нэгжүүдэд хүлээлгэн өгсөн.<br>- 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн №10 тоот хурлаар нийт 39 аж ахуйн нэгжийн 762 гэрчилгээ шинээр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | олгох болон сунгуулах, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцсэн.Үүнээс:<br>· Шинээр олгохоор шийдвэрлэгдсэн: 13<br>· Өөрчлөлт оруулахаар шийдвэрлэгдсэн: 1<br>· Сунгахаар шийдвэрлэгдсэн: 8<br>· Дараагийн хурлаар шийдвэрлэхээр хойшлуулсан: 11<br>· Буцаахаар шийдвэрлэгдсэн: 7<br>Хурлын тэмдэглэлийг хөтөлж ажлын хэсгийн гишүүдэд танилцуулан, гэрчилгээг олгох 22 аж ахуйн нэгж (324ш гэрчилгээ)-ийг Зам, тээврийн хөгжлийн яаманд шилжүүлсэн.<br>Гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн санг бүрдүүлж хөтлөн, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.8-д заасны дагуу гэрчилгээ олгосон хуулийн этгээдүүдийн мэдээллийг ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т 2022 оны 5 дугаар сарын 31-ны өдөр тайлагнасан. Тайлант |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | хугацаанд ажлын хэсгийн хурлаар буцаахаар шийдвэрлэсэн 15 аж ахуйн нэгжийн албан бичгийг боловсруулан батлуулсан бөгөөд “Тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлтийн цахим систем”-ээр буцаасан. |
| **15. Гэрчилгээжүүлэлтийн сарын статистик мэдээг бэлтгэн боловсруулах, ажлын хэсгийн чиг үүргийн дагуу “Тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлтийн цахим систем”-д ажиллах** | Гэрчилгээжүүлэлтийн сарын статистик мэдээг бэлтгэн боловсруулах, ажлын хэсгийн чиг үүргийн дагуу “Тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлтийн цахим систем”-д ажиллах | • Гэрчилгээжүүлэлтийн сарын статистик мэдээг боловсруулж Төвд танилцуулсан байна. (50%) (100%) (100%)<br>• Системтэй холбоотой засвар, шинэчлэлтийн ажилд санал хүргүүлэн ажилласан байна. (50%) (100%) (100%) | 6.3% | 6.3% | **Н.Номин** 22/05/31<br>Гэрчилгээжүүлэлтийн ажлын хэсгийн 2022 оны 5 дугаар сарын 13, 27-ны хурал хуралдахын өмнө нийт 69 байгууллагад ажлын хэсгийн гишүүд нэг бүрийн ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл гаргаж, шилэн дансанд байршуулулахаар Төвийн нягтлан бодогч С.Золзаяад тухай бүр хүлээлгэн өгсөн. “Тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлтийн цахим систем”-д сунгуулах хүсэлт ирүүлсэн компаниудын эрхийн төрлийг идэвхижүүлэлт хийлгэх тухай саналыг төвийн систем хариуцсан мэргэжилтэнд 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр мэдэгдсэн.<br>Гэрчилгээжүүлэлтийн 2022 оны 5 дугаар сарын статистик мэдээг бэлтгэн боловсруулж Төвийн удирдлага болон мэргэжилтнүүдэд танилцуулсан. |